



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/009

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам"-ын 3.6.1, 3.6.18 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан хаагчдын томилолтын зардалд 1,190,000 (нэг сая нэг зуун ерэн мянга) төгрөг, Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр хяналт шалгалт хийх шатахууны зардалд 5,301,200 (таван сая гурван зуун нэг мянга хоёр зуу) төгрөг, нийт 6,491,200 (зургаан сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг зарцуулсугай

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай

3. Зардалд шаардагдах 6,491,200 (зургаан сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 209 дүгээр захирамжийн хавсралт



2024 ОНЫ ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭР, ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭХЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ХИЙСЭН ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Арга хэмжээний ажил, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	1	2	3	4
1	Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх хамгаалах чиглэлээр хяналт шалгалт хийх шатахууны зардал А-92 бинзен	1430	2640	3,887,700
2	Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх хамгаалах чиглэлээр хяналт шалгалт хийх шатахууны зардал Дизель түлш	100	3590	359,000
		285	3700	1,054,500
3	Ой хээрийн түймэр, хууль бус мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх хамгаалах чиглэлээр хяналт шалгалт хийх шатахууны зардал Тосол	15л	7500	112,500
Нийт дүн				5,301,200

АЛБАН ХААГЧДЫН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Албан хаагчдын албан томилолт	Нэг хүний томилолтын зардал	Хоног	Нийт томилолтын зардал
	1	2	3	4
1	Б.Янжиндулам	170,000	4	680,000
2	Ш.Бумандолгор	170,000	3	510,000
Нийт дүн		170,000	7	1,190,000